



**“ШАРЫН ГОЛ”
ХУВЬЦААТ КОМПАНИ**

45010 Шарын гол, Дархан-Уул аймаг

Утас: 7037-2235, Факс: 7037-2235

2021.04.23 № 1/295
танай _____-ны № _____-т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

“Шарын гол” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 13:00 цагт Улаанбаатар зочид буудлын хурлын танхимд хуралдуулахаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай 05 дугаар тогтоол гарч танай байгууллагад хүргүүлсэн билээ.

Гэвч дэлхий нийтэд тархаад байгаа корона вирус /Ковид-19/ цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 91 тоот тогтоолоор 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цаг хүртэл Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хатуу хөл хорио тогтоосон бөгөөд тус хөл хорио 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн өглөөний 06:00 цаг хүртэл сунгагдсантай холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 13:00 цагт хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаа цахимаар буюу ZOOM application ашиглан хуралдаж, саналын хуудсыг биечлэн авахгүйгээр, и-мэйл хаягаар хүлээн авч санал хураах ажиллагааг зохион байгуулахаар болсныг үүгээр мэдэгдэж байна.

Хурлын шинэчлэгдсэн зарыг өөрийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэж өгч бидний ажилд туслалцаа үзүүлнэ үү.

Жич: Хувьцаа эзэмшигчдийн хурлын шинэчилсэн зарыг хавсаргав.

Хавсралт хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х.ХУЯНГА



Гүйцэтгэх захирлын 2021 оны 04 дүгээр сарын 23 -ны өдрийн № 1/2021 тоот албан бичгийн хавсралт

“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 91 тоот тогтоолоор 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цаг хүртэл Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хатуу хөл хорио тогтоосон бөгөөд тус хөл хорио сунгагдах нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 13:00 цагт Улаанбаатар зочид буудлын хурлын танхимд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаа цахимаар буюу ZOOM application ашиглан хуралдаж, саналын хуудсыг биечлэн авахгүйгээр и-мэйл хаягаар хүлээн авч санал хураах ажиллагааг зохион байгуулахаар болсныг үүгээр мэдэгдэж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр: 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн ТУЗ-ийн 2021 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
4. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл

2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 13:00 цагаас <https://zoom.us/download> линкээр ZOOM програмыг татан авч Meeting ID: 201 188 1864 , Passcode:1965 оруулж нэвтрэн “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоно уу.

“Шарын гол”ХК-ийн Хувьцаа эзэмшигчид брокер дилерийн компаниудаараа дамжуулах болон шууд 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 13:00 цаг хүртэл enkhtaivan@sharyngol.mn и-мэйл хаягаар баталгаажуулсан саналын хуудсаа /сканердан PDF файл хэлбэрээр, эсхүл зурган боломжит бусад хэлбэрээр/ явуулж саналаа өгч болно.

Холбоо барих утас:88026677